

БАТЛАВ.
СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН
ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГА
У. БАТМӨНХ
БИЕИЙН ТАМИР
СПОРТЫН ГАЗАР
ТБАГУУТ

2023 оны 12 дугаар сарын 22-ны өдөр



**2024 ОНД ЗОХИОН БАЙГУУЛАХ УЛС, БҮС, АЙМГИЙН
АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭН, НИЙТИЙН БИЕИЙН ТАМИРЫН
АРГА ХЭМЖЭЭНИЙ НЭГДСЭН ТӨЛӨВЛӨГӨӨ**

Нэг. Зорилго

Монгол Улсын Биеийн тамир спортын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, 10.1.7 дахь заалт, Аймгийн засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, Спортлог- Сэлэнгэчүүд хөтөлбөрийн хүрээнд хүүхэд, өсвөр үе, залуучууд, насанд хүрэгчдийг спортын уралдаан тэмцээнд өргөнөөр оролцуулах, авьяасыг нээн илрүүлэх, ур чадвартай тамирчдыг хөгжүүлэх Монголын оюутны спортын наадам, Монголын бүх ард түмний спартакиад, Үндэсний спортын наадам, Монголын Хүүхдийн спортын наадмын уралдаан тэмцээнүүдэд бэлтгэн оролцуулахад чиглэгдэнэ.

**Хоёр. Аймгийн аварга шалгаруулах тэмцээний удирдлага зохион
байгуулалт**

Монголын оюутны спортын наадам, Монголын бүх ард түмний спартакиадад бусад тэмцээнүүдэд оролцох тамирчдыг сонгон шалгаруулж аймгийн Засаг даргын захирамжаар батлагдсан ажлын хэсгийн дүгнэлтээр, өсвөр, залуучууд, насанд хүрэгчдийн Улсын аварга шалгаруулах тэмцээнүүд, Биеийн тамир спортын газрын даргын тушаалаар батлагдсан спортын төрлүүдийг холбоо клубүүдтэй хамтран зохион байгуулна.

Гурав. Аймгийн аварга шалгаруулах тэмцээний хугацаа үе шатууд

Аймгийн аварга шалгаруулах тэмцээнийг 2023 оны 12 дугаар сараас 2024 оны 12 сарын 01 хүртэл 2 үе шаттайгаар зохион байгуулна. Үүнд:

1-р үе шат. Сум сургууль байгууллагын хэмжээнд

2-р үе шат. Аймгийн хэмжээнд

Тэмцээн уралдаан нь халдварт өвчний улмаас Улсын онцгой комиссын шийдвэрийн дагуу явагдахгүй өнгөрсөн төрлүүдийг тусгай заавар гарган Улсын тэмцээний хугацаатай уялдуулан зохион байгуулна.

Дөрөв. Улс, Аймгийн аварга шалгаруулах тэмцээн, нийтийн биеийн тамирын уралдаан тэмцээний төрөл, зай, жин, хугацаа, явагдах газар, нэг байгууллагаас сонгох тамирчдын тоо.

№	Спортын төрөл	төрөл, зай, жин, ангилал	Улсын аваргын хуваарь	Нэг байгууллагаас оролцох тоо хязгаар			Аймгийн аваргын тэмцээний болох хугацаа	Зохион байгуулах газар, хаана
				хөв	Охид	Нийт		
Аймагт хүлээн авах Улсын аварга шалгаруулах тэмцээн								
1	Таеквондо	Залуучууд					2024 оны 3 сарын 2-3	Сэлэнгэ аймаг
2	Буудлага	Өсвөр үе					2024 оны 3 сарын 24	Сэлэнгэ аймаг
3	Явган аялал	Ахмад		3	2	6	2024 оны 7 сарын 27-29	
4	Мөсөн сурын харваа	Насанд хүрэгчид					2024 оны 1 сарын 24-28	Сэлэнгэ аймаг Ерөө сум
Аймгийн аварга шалгаруулах тэмцээн								
1	Чөлөөт бөх Өсвөр	эр 45,48,51,55,58,62,68,71,80, 90,110 Эм 38,40,43,46,49,52,56,60,65,73	U-17 4.19-21 U-15 5.17-19	10	10	21	3 сарын 1-3	Ерөө
	Насанд хүрэгчид	Тусгай заавраар		+	+	+		Сүхбаатар
2	Жудо Өсвөр	3 насаар бага 2011 24,30,34,38,42,50,55,60,+60 32,36,40,44,48,52,57,63,+63 Дунд нас 2009-2010 34,38,42,46,50,55,60,66,73,+73 36,40,44,48,52,57,63,+63, Том нас 2007-2008 50,55,60,66,73,81,90,+90 40,44,48,52,57,66,70,+70	5.2-5	14	10	25	1 сарын 12-14	Мандал сум Түнхэл тосгон
3	Самбо Өсвөр	Тусгай заавраар эр 48.52.56.60.65.70.75.81. эм 40,44,48,52,57,+63 -63	4.3-5	8	6	15	3 сарын 9-10	Сайхан сум
4	Даам	8-10.11-13.14-15.16-17	2 сард	5	5	11	1 сарын 13-14	Баянгол сум
6	Сумо өсвөр	10-12 13-15, 16-17 2007 оноос		6	-	7	3 сарын 1-3	Ерөө,
7	Шатар Өсвөр	6 насны охид хөвгүүд	4.1-5	12	12	25	3 сарын 9-10	Цагааннуур сум Шатрын холбоо
8	Волейбол Өсвөр	2007 оноос хойш Ерөө, Цагааннуур бүсээс эрэгтэй эмэгтэй 1 баг,	U-17-18 3 сар	10	10	21	3 сарын 9-10	БТСГазар волейболын

		Сүхбаатар Мандал, Сайхан бүсээс эрэгтэй эмэгтэй 2 баг	U-15-16 4 сар							холбоо
9	Хөнгөн атлетик	14-15 нас 16-17 нас	5.11-12	8	8	17	4 сарын 13-14			БТСГазар
10	Ширээний теннис	ганцаарчилсан, холимог хос 12,13-15,16-17 нас Ахмад, насанд хүрэгчид	4.4-7	3	3	7	3 сарын 16-17			БТСГазар ШТХолбоо
11	Таеквондо	Сонгон шалгаруулалтаар		12	12	25				БТСГазар
12	Шагайн харваа	Насанд хүрэгчид	5.16-18	6			Тусгай заавраар			Сүхбаатар
13	Бокс	Сонгон шалгаруулалтаар		10	8	19				БТСГазар
14	Бадминтон	Ганцаарчилсан, дан хос, холимог хос		2	2	5				БТСГазар
15	Сагсан бөмбөг	2007 оноос хойш 17 нас Ерөө, Цагааннуур бүсээс эрэгтэй эмэгтэй 1 баг, Сүхбаатар Мандал Сайхан бүсээс эрэгтэй эмэгтэй 2 баг		10	10	21	4 сарын 19-21			БТСГазар СБХолбоо
		16 насны аймгийн аварга шалгаруулах тэмцээн сургууль бүрээс 1 баг		10	10	21	4 сарын 26-28			Мандал сум
16	Хөл бөмбөг Шигшээ	Мөрөөдлийн гоол 12 нас 14 нас 16 нас	U-16 U-14 4.25-5.14	45	45	92	4 сарын 5-7			Сүхбаатар
17	Үндэсний бөх	тусгай заавраар .2007,2008, 2009	10.23-25	4	-	5	Тусгай заавраар			Мандал
18	Дугуй	Цолтой, цолгүй бөхчүүдийн ААШТ 2007 оноос хойш 17 нас		+	+	+	Тусгай заавраар			Сүхбаатар
19	Дардс	Тусгай заавраар	1 сар20-21	+	+	+	5 сард тусгай заавар			Дугуйн холбоо
20	Волейбол Ахмад	Тусгай заавраар	2 сар	10	10	21	2023 оны 11 сар			Мандал сум
21	Үндэсний сур	Өсвөр, насанд хүрэгчид	6.22-25	+	+	+	тусгай заавар			Сүхбаатар сум
22	Усан сэлэлт өсвөр залуучууд ААШТэмцээн	Тусгай заавраар	3.29-31	+	+	+	3 сар 2-3			УССТөв Аймгийн ЗДТГ
	Насанд хүрэгчид	Тусгай заавраар	1.19-21	+	+	+				УССТөв

Тэмцээний тодотголууд.

1. Тэмцээний насны ангилал. Аймгийн аварга шалгаруулах тэмцээний насны ангиллыг ЗГХАБТСГазраас баталсан 2024 оны спортын уралдаан тэмцээний нэгдсэн төлөвлөгөө, спортын холбоодуудын зааврыг үндэслэн гаргасан болно.
2. Тэмцээнд зөрчил гаргасан тохиолдолд. Өсвөрийн баг тамирчдын тэмцээн уралдаанд хүүхдийн нас дарсан, бичиг баримтын зөрчил гаргасан, хэрүүл маргаан үүсгэсэн, спортын бус бүдүүлэг багш дасгалжуулагч нартай зөрчлийн тухай хуулиар хариуцлага тооцох, торгууль оногдуулах ба тамирчныг хасах, багаар нь хасах, хөөх дасгалжуулагч багш нарыг уралдаан тэмцээнд орох эрхийг хасах ба Зөрчлийн тухай хуулийн 6,19 зүйлд заасны дагуу арга хэмжээг авч ажиллах тул анхааруулж байна.
3. Тэмцээнд оролцох тамирчдын хувийн ариун цэвэр сахих, спортын төрлийн онцлогоос шалтгаалах бэртэл гэмтлээс урьдчилан сэргийлэх зааварчилгаа өгсөн байна.
4. Тамирчин дасгалжуулагчийн мандатны талаар. Олон улсын болон Монголын спортын холбоодуудын жишгийн дагуу уралдаан тэмцээнд оролцож байгаа өсвөрийн тамирчдын мандат буюу тэмцээнд оролцох хураамж хувь хүн 5000-10000 төгрөг, баг 30000-50000 төгрөг хүртэл, насанд хүрэгчид хувь 20000 баг 100000 төгрөг хүртэл хураамж төлж болно.
5. Спортын бага олимп нь Хүүхдийн спортын наадамд оролцох тамирчдыг урьдчилан бэлтгэх зорилгоор нэгдсэн журмаар заавар гаргаж үе шаттайгаар явуулан тамирчдыг сонгон шалгаруулж бэлтгэлд хамруулах чиглэлийг агуулна.Тэмцээний дүнг гаргахдаа харьяа сургууль бүр дээр гаргах тул анхаарах. Насны хувьд 2007-2008 оны 1 сарын 1 нээс хойш төрсөн байна.
5. Сум орон нутгийн хэмжээнд явагдаж байгаа спортын төрлүүдэд оролцож байгаа тамирчин болон дасгалжуулагч багш нар хүний эрхзүйг дээдлэн орчин нөхцөлд нөөц бололцоог ашиглан хүндрэл чирэгдэл гаргахгүй, ёс зүйг дээдлэн хамтран ажиллаж спортоо хүндэтгэх
6. Нийтийн биеийн тамирын арга хэмжээий талаар Нийтийн биеийн тамирын төлөвлөгөөнд орсон арга хэмжээнүүд нь Сэлэнгэ аймгийн хэмжээнд зохион байгуулагдах үлгэрчилсэн төлөвлөгөө болно

№	Зохиогдох арга хэмжээнүүд	Тэмцээний төрөл	Арга хэмжээ зохион байгуулах газар	Хугацаа	Хамтран ажиллах
1	Цасны баяр	Өртөөт марафон	Зорилтот сумдад	2023 2 сард	Аж ахуйн нэгж иргэд

2	Засаг даргын нэрэмжит цомын төлөөх Төрийн албан хаагчдын тэмцээн	Сагс, волейбол, шатар, ширээний теннис олс	Сүхбаатар	IV улиралд	Аймгийн ЗДТГ Хэлтэс, агентлагууд
3	Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд явагдах арга хэмжээ	2-3 төрлөөр	Сүхбаатар	Тусгай заавраар	Аймгийн ХБИХ
4	Ахмадын баярын арга хэмжээ	Тусгай заавраар	Сүхбаатар	10 сард	Аймгийн ахмадын холбоо
5	СӨБоловсролын ажилчдын дундах биеийн тамирын арга хэмжээ	Тусгай заавраар	Сүхбаатар	1 сарын 19-21	Биеийн тамирын алба, СӨБайгууллага
6	Хүүхдийн баярын арга хэмжээ	Дугуй ролька скейт	Сүхбаатар	6 сарын 1	Сумын ЗДТГ ХГБХГ
7	Замд гарья спортын цэнгүүн	Хөгжилтэй тоглоом Тусгай заавраар	Сайхан сум	II улиралд	Сайхан сумын ЗДТГ Спорт клуб
8	Мандал бага лиг	Сагсан бөмбөг сонирхогчид	Мандал	Тусгай заавраар	Мандал Спорт цогцолбор
9	Ерөө бүсийн спортын 5 төрөлт тэмцээн	Сагс, волейбол, олс, шатар, теннис	Ерөө сум	Тусгай заавраар	Ерөө сум ЗДТГ Спорт цогцолбор
10	Хүүхдийн спортын бэсрэг наадам	Сагс, волейбол Тусгай заавраар	Мандал	Тусгай заавраар	Мандал Спорт цогцолбор
11	Төрийн албан хаагчдын спортын нөхөрсөг тэмцээн	Спорт, биеийн тамирын 7 төрөл	Сүхбаатар	11 сар	Аймгийн ЗДТГ Бүх сум
12	Өсвөр үеийн баруун бүсийн аварга шалгаруулах тэмцээн	Волейбол 7 сум	Баруунбүрэн	Тусгай заавраар	Баруунбүрэн Спорт цогцолбор
13	Ардын хувьсгалын 103 жилийн баяр наадмын арга хэмжээ	Тусгай төлөвлөгөөтэй	Бүх суманд	7 сард 1-11	Тухайн сумдын ЗДТГ

Тав. Тэмцээний бичиг баримт бүрдүүлэлт, мэдүүлэг хүлээн авах

Тэмцээнд оролцох тамирчдын мэдүүлэгийг тэмцээн эхлэхээс 7 хоногийн өмнөөс цахимаар авч эхэлнэ. Мэдүүлэгийг тухайн сумын Засаг дарга, сургуулийн захирал, байгууллагын дарга, спорт цогцолборын даргын гарын үсэг, тамга тэмдгээр баталгаажуулсан эмчийн үзлэгт хамрагдсан албан ёсны баримт байна. Эрхийн хураамжийг багуудад нэгдсэн журмаар олгох бөгөөд эрх олгоход доорхи баримтуудыг бүрдүүлсэн байна.

- Үүнд. 1. Сурагчийн хувийн хэрэг
2. Иргэний үнэмлэх
3. Зураг 3x4 1%
4. Эмчийн тодорхойлолт
5. Тэмцээний эрхийн төлбөр

Мандат олгосны дараа тухайн төрлийн техникийн зөвлөгөөнийг хийх бөгөөд багийн ахлагч, дасгалжуулагч нар сугалааг хийнэ.

Зургаа. Шагнал урамшуулалт

Аймгийн аварга шалгаруулах тэмцээн, нийтийн биеийн тамирын арга хэмжээний шагналыг зохион байгуулж буй газрууд хамтран гүйцэтгэх бөгөөд тамирчдын ирж, очих, байр хоолны зардлыг тамирчдаа оролцуулж байгаа байгууллага бүрэн хариуцна.

СЭЛЭНГЭ АЙМГИЙН БИЕИЙН ТАМИР СПОРТЫН ГАЗАР